



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2006 оны 11 сарын 27 өдөр


Дугаар 422

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам”, Сангийн сайдын 2006 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 1-6/3715 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батдэлгэр овогтой Нямдоржийг 2006-2007 оны хичээлийн жилээс АНУ-ын Денвер хот дахь Колорадогийн их сургуулийн магистрантурт төрийн захиргааны чиглэлээр Сургалтын төрийн сангийн зээлээр Сангийн яамны захиалгын дагуу 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.
2. Б.Нямдоржийг хэлний бэлтгэл сургалтаа дүүргэн тус сургуулийн үндсэн ангид элссэний дараа сургалтын төлбөрийг нь шилжүүлэхийг Сургалтын төрийн сангийн захирал П.Лхагвасүрэнд даалгасугай.
3. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



САЙД

Ф.Доржсүрэн

Ө.ЭНХТҮҮВШИН

Бат-Эрдэнэ - 214